

АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН
Т.ДЭЛГЭРМААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
НЭГ. "БАГШ, СУРАГЧДЫН СУРЧ БОЛОВСРОХ ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЖ, БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, СУРГАЛТЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.1	Сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, хамран сургалтыг нэмэгдүүлэх	ЕБС, СӨББ-ийн хамран сургалтын хувиар	ЕБС-99,8 СӨБ-96,9	ЕБС-99,8 СӨБ-97,0	2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 6 сургуулийн дүнгээр 319 бүлэгт 11188 сурагч буюу өмнөх хичээлийн жилээс бүлэг 8-аар, сурагч 477 буюу 4,3 хувиар өсч, анги дүүргэлт 35 буюу 1,8 хувиар өссөн. Насан туршийн боловсролын төвийн боловсрол нөхөн олгох хөтөлбөрт 23 хүүхэд суралцаж, боловсрол эзэмшиж байна. Сумын хэмжээнд сургуулийн насны 9815 хүүхэд байгаагаас сургууль завсардсан 7 хүүхэд байна. Хамран сургалт 99.8 хувь буюу өмнөх хичээлийн жилээс 0.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Сумын хэмжээнд цэцэрлэгийн насны 3576 хүүхэд байгаагаас 2024-2025 оны хичээлийн жилд төсвийн 14, хувийн хэвшлийн 4 цэцэрлэгийн 97 бүлэгт 3603 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 95,1 хувьтай байна. 15 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэхээр хамран сургалтын хувь нэмэгдэнэ.	2024.01.02 2024.12.01	100
1.2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын	Хамрагдалтын хувиар	88,0	88,5	Сумын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 172 хүүхэд байгаагаас 12 нь 0-1 насны хүүхдүүд байна. Боловсролын үйлчилгээнд хамрагдах 160 хүүхэд байгаагаас 2024-2025 оны	2024.01.02 2024.12.01	100

<p>1.3</p> <p>Боловсролын үйлчилгээг чанартай зохион байгуулж, дотоод, гадаадын их дээд</p>	<p>Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноогоор</p>	<p>538.3</p>	<p>539,0</p>	<p>хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн жирийн ангид 57, сургуулийн өмнөх боловсролд 15, 2 дугаар сургуулийн тусгай бүлэгт 38, тусгай цэцэрлэгт 40, нийт 150 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа нь нийт хүүхдийн 93,7 хувийг эзэлж байна. Өмнөх хичээлийн жилд тусгай цэцэрлэгийг 8 хүүхэд төгссөнөөс энгийн цэцэрлэгт 2 хүүхэд дэвшин суралцсан. 2 дугаар сургуулийн тусгай бүлгийг 3 хүүхэд төгссөнөөс Боловсролын их сургуульд 1, Политехник коллежид 1, 2 хүүхэд энгийн ангид шилжин суралцсан. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс хамгаалах, аюулгүй байдлаа хангах чадавхыг нэмэгдүүлэх нь" сургалтыг 4 бүлэг 8 сэдвийн хүрээнд боловсролын байгууллагын ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулан зохион байгуулж, 90 багш, 150 эцэг эх, 350 гаруй сурагч хамрагдсан. 11 дүгээр тусгай цэцэрлэгт Алау нийгэмлэгийн 8 хүний бүрэлдэхүүнтэй баг 14 хоногийн хугацаатай ажиллаж, давхардсан тоогоор 120 гаруй эцэг эх, 40 гаруй багш, ажилчид, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн уламжлалт, сэргээн засах физик эмчилгээний тасгийн эмч мэргэжилтнүүдэд сургалт, зөвлөгөө мэдээлэл өгсөн. 11 дүгээр цэцэрлэгийн барилга 30 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</p>	<p>2024 оны хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалт 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдөр улс даяар зохион байгуулагдаж, ерөнхий боловсролын Мэргэд сургууль 598,4, Тэмүүлэл-Эрдэм сургууль 559,9, 4</p>	<p>2024.01.02 2024.12.01</p>	<p>100</p>
---	--	--------------	--------------	--	--	----------------------------------	------------

	<p>дүгээр сургууль 547,7, 2 дугаар сургууль 528,4, 1 дүгээр сургууль 510,6, 5 дугаар сургууль 500 хэмжээст оноо авч, элсэлтийн шалгалтын дундаж оноо 540,8 болж, өмнөх шалгалтаас 1,8 оноогоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад Өвөрхангай аймгаас 8 сурагч 800 оноо авсны 7 нь Арвайхээр сумын сурагчид байна. Эдгээр 7 сурагчид Засаг даргын Тамгын газраас тус бүр 1,0 сая төгрөгийн урамшуулал олгосон.</p>						
<p>1.4</p>	<p>Яслийн ажиллагааг үйл дэмжиж, хамрах хүүхдийн тоог нэмэгдүүлнэ.</p>	<p>Хамрагдсан хүүхдийн тоогоор</p>	<p>20</p>	<p>35</p>	<p>“Арвайхээр нархан” цэцэрлэгт 1,5-2 нас хүртэл 12 хүүхэд хамрагдаж, боловсролын үйлчилгээ авч байна. “Жаргалант ирээдүйн мөрөөдөл” хувийн цэцэрлэг нь 2023-2024 оны хичээлийн жилд 11 сараас 1,6 хүртэл насны 20 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулсан. Улаан бурхан өвчний дэгдэлт их байгаатай холбогдуулан 2024-2025 оны хичээлийн жилийн үйл ажиллагааг 10 сараас эхлүүлсэн. Тус цэцэрлэгт 10 сараас 1,7 хүртэл насны 25 хүүхэд суралцаж байна. Яслийн насны нийт 37 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.</p>	<p>2024.01.02 2024.12.01</p>	<p>100</p>
<p>1.5</p>	<p>24 цагийн ажиллагаатай цэцэрлэг байгуулах аж ахуйн иргэний санаачлагыг дэмжин хамтарч ажиллана.</p>	<p>Дэмжлэг үзүүлсэн тоогоор</p>	<p>-</p>	<p>1</p>	<p>“Арвайхээр нархан” цэцэрлэг хамрагдаж буй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдаас 24 цагийн цэцэрлэг шаардлагатай эсэх талаар судалгаа авахад уртасгасан цагаар ажилладаг цэцэрлэг шаардлагатай гэсэн судалгаа гарсны дагуу тус цэцэрлэг нь уртасгасан цагаар буюу өглөөний 07:30 цагаас оройн 20:00 цаг хүртэл ажиллаж байна. 2024-2025 оны хичээлийн жилд 2 холимог бүлгийн 50 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Засаг даргын Тамгын</p>	<p>2024.01.02 2024.12.01</p>	<p>100</p>

		ХОЁР. "ХОТЫН СОЁЛ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД			
	газраас уртасгасан цагаар ажиллахад 5,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.				
2.1	Ерөнхий боловсролын сургуулийн "Хотын соёл" хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоогоор	6	2024.01.02 2024.12.01	50
2.2	"Хотын соёл" хөтөлбөрийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан хурлын тоогоор	1	2024.01.02 2024.12.01	100
<p>Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуультай хамтран "ARVAIKHEER CITY TOUR" танхимаас гадуурх сургалт буюу экскурс аяллыг Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцах, эх орноороо бахархах үзэл төлөвшүүлэх зорилгоор 4-5 дугаар ангийн 360 гаруй хүүхдийг хамруулан зохион байгуулсан. Тус аяллын хүрээнд сурагчид 256 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцаж, нийтийн тээврээр зорчих соёлд суралцах, эх орноороо бахархах, цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх зэрэг агуулгын хүрээнд мэдлэг, чадвар эзэмшсэн үр дүнтэй үйл ажиллагаа болсон.</p> <p>2024 оны 05 сарын 24, 27-ны өдрүүдэд Арвайхээр сумын сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудын "Хотын соёл" хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын дунд харилцан туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 6 сургууль, 14 цэцэрлэгийн 120 гаруй багш мэргэжлийн хөгжлийн бүлгээрээ хамтарч бүтээлийн үзэсгэлэн гаргаж, хэрэгжилт үр дүнгээ танилцуулж, харилцан туршлага солилцон ажиллалаа. Сургууль-4, цэцэрлэг-5 нийт 9 мэргэжлийн хөгжлийн бүлгийн бүтээлч хандлага, тэргүүн туршлагыг шалгаруулж батламж, мөнгөн шагналаар шагнасан.</p>					
<p>ГУРАВ. АХМАД НАСТНУУДЫН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭНД СУУРИЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, НИЙГМИЙН ИДЭВХ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</p>					

3.1	Сумын ахмадуудын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	1	<p>Зорилтот бүлгийн ганц бие, харж хандах үр хүүхэдгүй 40 ахмадыг Өгөөмөр сувилалтай хамтран 2024 оны 02 дугаар сард үнэ төлбөргүй сувилалд амраасан. Улаан загалмайн хорооны олон нийтийн оролцоонд түшиглэсэн ахмадын өдрийн үйлчилгээнд 47 ахмадыг хамруулсан.</p> <p>Аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтран зохион байгуулсан "Эрүүл чанартай урт наслахын төлөө" нэгдсэн өдөрлөгт 180 гаруй ахмад хамрагдлаа. Тус өдөрлөгөөр Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн хүрээнд "Цахимд шилжье" гэсэн иргэдэд мэдээлэл өгөх булан ажиллуулж 30 гаруй ахмадад утсан дээр нь E-Mongolia апп суулган, хэрэглээний заавар өгч, 50 гаруй ахмадад "И кидс", What3word апп-ын хэрэглээний заавар бүхий брошур тарааж, ахмадуудыг цахимаар төрийн үйлчилгээг авах боломжийг нэмэгдүүлсэн.</p>	2024.01.02 2024.12.01	100
3.2	Байгууллагын харьяалалтай ахмадуудыг хүлээн авч, санал хүсэлтийг сонсох, шийдвэрлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	1	<p>Сар шинийн баяр, Ахмадын баярыг тохиолдуулан Засаг даргын Тамгын газарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2 удаа зохион байгууллаа. Нийт 35 ахмад настанд тус бүр гарын бэлэг гардуулж, хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн, ахмадуудынхаа санал хүсэлтийг сонслоо. Дээрх 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулахад Тамгын газраас 5,743,490 (таван сая долоон зуун дөчин гурван мянга дөрвөн зуун ер) төгрөгийг зарцуулсан.</p>	2024.01.02 2024.12.01	100
ДӨРӨВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД						

4.1	<p>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, биелэлтийг хагас бүтэн жилээр тайлагнах, хурал болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах</p>	<p>Тайлан мэдээний үр дүнгээр</p>	<p>-</p>	<p>Байгууллага, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь тайлагнаж ажилласан байна</p>	<p>Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, Зорилтот жилийн ажлын төлөвлөгөө, Зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлт, сумын Засаг даргатай байгуулсан аймгийн Засаг даргын гэрээний хагас жилийн биелэлт зэрэг бодлогын баримт бичгүүдийн холбогдох заалтын тайланг Засаг даргын Тамгын газарт өгч хэвшсэн.</p>	<p>2024.01.02 2024.12.01</p>	<p>100</p>
4.2	<p>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг болон хууль эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх</p>	<p>Ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн хувь</p>	<p>100</p>	<p>2024 оны 11 сарын байдлаар 10 захирамжийн төсөл, 12 тушаалын төсөл боловсруулан, хугацаатай ирсэн 3 албан бичгийн хариуг явуулсан.</p>	<p>2024.01.02 2024.12.01</p>	<p>100</p>	
	<p>Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажилласан эсэх</p>	<p>Зөрчилгүй ажилласан байна.</p>	<p>Зөрчилгүй ажилласан байна.</p>	<p>Байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажиллаж, албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг танилцуулсан. "Ёс зүйгээрээ манлайлья" өдөрлөгийг байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ёс зүйн зөрчил гаргалгүй ажилласан.</p>	<p>2024.01.02 2024.12.01</p>	<p>100</p>	

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Сумын хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	Хүүхийн баярын арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	-	-	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан сумын Хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. Хүүхдүүдийн дунд насны ангиллаар 3х3 сагсан бөмбөг, алтан хонх, ороп mic тэмцээнүүдийг зохион байгуулж, шалгарсан хүүхдүүдийг шагнаж урамшуулсан.	2024.01.02 2024.06.10	100
2	Уламжлалт хамтын ажиллагаатай Франц улсын Аллиер мужийн Апау нийгэмлэгийн төлөөлөгчийн багийг айлд зочлуулж, монгол ахуй, ёс заншилтай танилцуулах	Арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	-	-	Франц улсын Аллиер мужийн Апау нийгэмлэгийн төлөөлөгчийн багийг Арвайхээр хот болон монгол ёс заншил, малчин айлын амьдрал ахуйтай танилцуулах үйл ажиллагааг 2024 оны 04 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгууллаа. Апау нийгэмлэгийн төлөөлөгчийн багийг Арвайхээр сумын 9 дүгээр багийн залуу малчин Г.Лодойгийн зочлуулж, Монгол ёс заншил, мал аж ахуй, уламжлалт хоол хүнс, монгол гэртэй танилцуулсан. Дээрх арга хэмжээг зохион байгуулахад Засаг даргын Тамгын газраас 1,511,306 (нэг сая таван зуун арван нэгэн мянга гурван зуун зургаа) төгрөгийг зарцуулсан.	2024.01.02 2024.06.10	100
3	Хүмүүн бичигтэн арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	-	-	Төрийн албан хаагчид, иргэд олон нийтийн үндэсний бичгээрээ унших, бичих чадварыг дээшлүүлэх хэрэглээг нэмэгдүүлэх "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас 2024 оны 02 дугаар сарын 10-04 дүгээр сарын 15-ны хооронд зохион байгуулсан "Хүмүүн бичигтэн" аянд	2024.01.02 2024.06.10	100

				оролцож, аяны хүрээнд 8 ажлыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж, аяны хүрээнд зарласан уралдаанд амжилттай оролцож, хамт олноороо 2 дугаар байрт шалгарсан.			
4	Сумын аварга шалгаруулах ахмадын хийн дасгалын тэмцээнийг зохион байгуулах	Арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	-	Сумын аварга шалгаруулах ахмадын хийн дасгалын тэмцээнийг 2024 оны 10 дугаар сарын 29-ны өдөр зохион байгуулсан. Тэмцээнд 9 баг оролцож, 1 дүгээр байрт 12 дугаар баг, 2 дугаар байрт 10 дугаар баг, 3 дугаар байрт 3 дугаар баг, тусгай байрт 5, 7 дугаар багийн ахмадууд шалгарч, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Дээрх тэмцээнийг зохион байгуулахад Засаг даргын Тамгын газраас 988,000 төгрөгийн зардал гарсан.	2024.01.02 2024.10.29	100	
Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт							
Гүйцэтгэлийн түвшин							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Отгон тэнгэр их сургуульд "Эрх зүй"-н чиглэлээр суралцах	Улирлын хичээлд бүрэн хамрагдах	-	Улирлын сургалтад хамрагдаж төгсөх	Отгонтэнгэр их сургуулийн эрх зүйн ангид элсэн 1,2, 3 улирлын хичээлд бүрэн хамрагдсан.	6 2024.01.02 2024.12.01	7 100
2	Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад хамрагдах	Сертификат авсан байна	-	1	Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд шатны сургалтад хамрагдсан.	2024.01.02 2024.06.10	50


 Т ДЭЛГЭРМАА

ТАЙЛАН ГАРГАСАН: НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН
 2024 оны 11 дүгээр сарын 25